



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/189

Хэрлэн сум

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/51, А/69 дугаар тушаалаар батлагдсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай хүүхдэд үйлчилгээ үзүүлэх зорилготой хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай,

Хорооны дарга:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
нарийн бичгийн дарга

-Аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн  
Ерөнхий Шүүгчийн туслах /зөвшилцсөнөөр/

-Аймгийн Прокурорын газрын Хэрэг бүртгэх,  
мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих  
хяналтын прокурор, хууль цаазын зөвлөх  
/зөвшилцсөнөөр/

-Цагдаагийн газрын дарга

-Боловсрол, соёл урлагийн газрын дарга

-Эрүүл мэндийн газрын дарга

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

-Аймгийн Өмгөөллийн зөвлөлийн дарга  
/зөвшилцсөнөөр/

-Скаутын зөвлөлийн дарга

Хорооны нарийн бичиг:

-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын  
дарга

01 981

2//.

2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд хагас жил тутам ажлаа тайлагнахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /Л.Бат-Октябрь/-нд үүрэг болгосугай.

3. Бор-Өндөр суманд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог холбогдох журмын дагуу байгуулж ажиллахыг Засаг дарга /П.Чинбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА